



# ДОРНОД АЙМГИЙН ЧУЛУУНХОРООТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

2024.06.20

# МАНЙ ХАМТ ОЛОН

Нийт багш, ажилчид – 38, удирдах ажилтан – 4, багш- 18, тэргүүлэх зэрэгтэй багш – 8, заах аргач зэрэгтэй багш – 5, мэргэжлийн зэрэгтэй багшийн эзлэх хувь – 72%





# 394 СУРАЛЦАГЧ



**БАГА  
АНГИД**

**180**



**ДУНД  
АНГИД**


**148**




**АХЛАХ  
АНГИД**

**66**

# 1. Суралцагч зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй, бэлэн байдлыг хангах













### Цахим хичээлийн сан

1. Математикийн хичээлийн 52
2. Монгол хэлний хичээлийн 35 үсгийн цахим хичээл болон бусад 61 хичээл
3. Хүн орчин хичээлийн сан 10
4. Байгалийн ухааны сан 10 байна.

Name	Date modified	Type
1 анги	3/12/2024 8:31 PM	File folder
2 анги	3/12/2024 8:31 PM	File folder
3 анги	3/12/2024 8:31 PM	File folder
4 анги	3/12/2024 8:31 PM	File folder
5 анги	3/12/2024 8:31 PM	File folder



2. Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, тэгш хамруулан сургах, тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах

01

Сургуулийн насны ялгаатай хэрэгцээтэй 2 сурагч суманд амьдарч байна. Түүнийг сургуульд хамруулсан.



02

Хөгжлийн бэрхшээлтэй 5 хүүхдээс гадна сурлагаар хоцорсон, үеийнхэнтэй зэрэгцэн сурч чадахгүй байгаа суралцахуйн бэрхшээл тулгарсан 28 сурагчийг илрүүлэн тэднийг дэмжин ажиллалаа.



03

Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн сургуульд хамрагдалт 100% байна. Бага ангийн 2 багш, дунд ахлах ангийн 6 багш ялгаатай даалгавар боловсруулан сургалтандаа ашигласан.



04

Сурагчдын сурах чадварын ялгаатай байдлыг бууруулах зорилгоор сургуулийнхаа нэг давхрын үүдний зааланд давтлага хийн ажиллах орчинг бүрдүүлсэн.





2. Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, тэгш хамруулан сургах, тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах

05

2-р ангийн багш Л. Мөнхгэрэл, 3-р ангийн багш Х. Хүрэлчимэг нар хөгжлийн онцлогтой хүүхдүүдтэй тулж ажиллах хөтөлбөр боловсруулан ахиц амжилтыг тооцож, хийсэн бүтээлээр нь үнэлэн урамшуулж ирсэн.



06

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн орж гарах шатны гарцыг засварлсан. Тэдэнд тохирсон хэрэглэгдэхүүн, ном сурах бичгийг ашиглан хөгжих, сурах хэрэгцээг нь хангах, дасгал даалгавар ажиллуулж ирлээ.



07

ХБ хүүхдүүдийн эцэг эхэд “Тэгш хамруулан сургах” талаар сургалтыг явуулсан. Сурагчид минь анги хамт олонтойгоо сурч тоглож, наадаж, төлөвшиж, ахиц амжилт нь нэмэгдэж байгаад эцэг эхийн сэтгэгдэл өндөр байна.



08

ХБ хүүхдүүдийн сурах идэвхийг өрнүүлэн үлгэрийн үйл явдлыг ярих, зургийг дэс дараалалд оруулах дасгал, зурган уншлага хийж сургалтанд ашигласан.









### 3. Байгууллагын менежментийн төлөвлөлт, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох

**2023 онд** байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 3-р түвшинд үнэлэгдсэн ба энэ хичээлийн жилд түвшин ахиулах зорилготой ажиллалаа. Сургуулийн менежментийг сайжруулахаар багш ажилтнууд 3 удаа, хүүхэд эцэг эх, олон нийтийг хамруулсан хэлэлцүүлэг 2 удаа зохион байгуулж, асуудлаа тодруулсан.

Хэлэлцүүлгийн дүнд “Гэрийн даалгавар”, “Багшийн хөгжил, ээлжит хичээл нэг бүрийг чанаржуулах”, “Орчны засвар, тохижилт” “Эцэг эхийн дэмжлэг” гэсэн 4 тулгамдсан асуудлаа илрүүлж чадсан нь хамгийн ололттой байв. Эндээс тэргүүлэх зорилтууд тодорхой болсон.

Тэргүүлэх зорилтууд тодорхой болсноор сургуулийн менежментийн зураглал гарсан. Зураглалыг гаргахдаа хүүхдийн дүр төрхийг тодруулж, алсын хараагаа шинэчилсэн.

Тэргүүлэх зорилтоо биелүүлэх замаар “Хүүхэд бүрийн хүсэл зоригийг биелүүлж чадах” сургууль байх алсын хараагаа биелүүлнэ гэж төлөвлөсөн



### 3. ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжин, ээлжит хичээл нэг бүрийн бэлтгэлийг сайжруулах

1

Орчны засвар тохижилт


2


Эцэг эхийн дэмжлэг

4

Гэрийн даалгавар

3







### 3. Байгууллагын менежментийн төлөвлөлт, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, үр чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох

Сургуулийн менежментийг сайжруулж, нийт хүүхдүүд, тэдний эцэг эх асран хамгаалагч, багш ажилтныг нэгэн зорилгын дор нэгтгэхэд одоо байгаа байдал, цаашид хүрэх үр дүнгээ хамтран тогтоох нь юу юунаас илүү чухал байлаа.

АУБ бүр эцэг эх асран хамгаалагч, хүүхэдтэйгээ ажиллаж, үнэлгээний үр дүнгээ танилцуулан, асуудлаа тодорхойлж, ажлаа төлөвлөж чадсан. Хугацаа шаардсан ажил байсан боловч хийж чадсан.

Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээ өмнөх жилийнхтэй харьцуулсан илтгэл бэлтгэж сумынхаа ИТХ-д хүргүүлж хэлэлцүүлсэн. Үүний үр дүнд “Жишиг анги-3” 20.0 сая төгрөг, “Номын сангийн тохижилт” 20.0 сая төгрөгийг төсөвт тусгасан.

Багшийн ажлын байрандаа хөгжих боломжийг хангах зорилготой 4 МХБ хагас жил тутамд ажлаа төлөвлөж, тухай бүр тайлагнаж ажилласан. “Багш хүүхэд хамтдаа” МХБ шилдэг бүлгээр шалгарч, тайланг БШУГ-т хүргүүлсэн.

4. “Тэргүүлэх болон Зөвлөх багшийн манлайлал”-ыг дээшлүүлэх арга хэмжээ, ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш, ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх

01

ТЭРГҮҮЛЭХ  
БАГШИЙН МАНЛАЙЛАЛ

ТЭРГҮҮЛЭХ БАГШ – 8  
ЗААХ АРГАЧ БАГШ – 5  
ЗЭРЭГТЭЙ БАГШИЙН ЭЗЛЭХ ХУВЬ – 72,2%

02

НЭЭЛТТЭЙ ХИЧЭЭЛ

“Заах аргач” мэргэжлийн зэрэгтэй багш, “Тэргүүлэх” мэргэжлийн зэрэгтэй багш нарын өдөрлөгийг тус тусад нь зохион байгуулж, нээлттэй хичээл зааж туршлагаа түгээн дэлгэрүүллээ.

03

МЭРГЭЖИЛ  
СУРТАЛЧЛАХ ӨДӨРЛӨГ

Мэргэжил сурталчлах өдөрлөг, үзэсгэлэн гаргах, өөрийнхөө мэргэжлийг өвлүүлсэн шавь нарын судалгаа гаргах зэрэг ажил зохион байгуулж нийт багш нар, хүүхдүүдийг хамруулсан өргөн хүрээтэй ажил боллоо



#### 4. “Тэргүүлэх болон Зөвлөх багшийн манлайлал”-ыг дээшлүүлэх арга хэмжээ, ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш, ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх

04

АХМАД БАГШИЙН  
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Ахмад багш М. Санжмятав, Х. Цолмон, Б. Баяраа, Д. Март нартай хамтран “Сайхан бичигтэн” төсөл, “Ардын аман зохиолыг хөгжүүлэх”, “Дотуур байрны хүүхэд хөгжил”, “Бага ангийн багшийг дэмжих” төсөл, хүүхдийн багууллагын 100 жилийн ой угтсан ажлууд дээр ажиллаж байна.

05

ОЛОН УЛСЫН АРГА  
ЗҮЙН ӨДӨРЛӨГ

Хорьдох жилдээ ОХУ-ын Борзийн районы Соловьёвск тосгоны сургуультай хамтран ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд багшийг чадваржуулах, харилцан туршлага солилцох, хүүхдийг өдрөөр сургалт болон хөгжүүлэх үйл ажиллагаанд хамрууллаа.

06

ШИЛДЭГ  
ТУРШЛАГА ТҮГЭЭН  
ДЭЛГЭРҮҮЛЭХ

Багш бүр хичээлийн хэрэглэгдэхүүний үзэсгэлэнд оролцож, бага ангийн багш нар 4- 5 чиглэлээр үйл ажиллагааны тайлан тавьж сургууль болон аймгийн бага боловсролын багш нарт түгээн дэлгэрүүллээ.













## 5. Багш, ажилтан, албан хаагчдад стрессээс сэргийлэх, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах

Сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэхэд анхаарч ажилладаг. 7 хоног болгоны даваа гарагт шуурхай хийж ажлаа төлөвлөх, дүгнэх, ойлголтоо нэгтгэхэд чиглүүлдэг.

1


Багш, ажилтан, суралцагчдын ажиллаж, амрах тухтай орчин бүрдүүлэх зорилгоор 13 сая төгрөгний ажлыг хийсэн.

2

Ганцаарчилсан уулзалтыг багш, ажилтан, суралцагчидтай хийж хэвшсэн.

"Нийгмийн харилцаанд сэтгэл хөдлөл зүйгээ удирдах" сэдэвт сургалт, зөвлөгөөг багш, ажилчид, сурагчдад 2 удаагийн давтамжтай зохион байгуулсан

4




Сэтгэл ханамжийн судалгаан дээр тулгуурлан ажилладаг.

Гүйцэтгэлийн үнэлгээ болон сэтгэл ханамжийн судалгаан дээр тулгуурлан орчны тохижилт хийсэн.

3











6. Сургууль дотуур байрны орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, сурах, хөгжих, төлөвших үйл явцыг дэмжих тусгайлсан арга хэмжээг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх, үр дүнг тооцох

### Нэг

“Үе тэнгийнхний дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 6-12-р ангийн 82 сурагчдад зохион байгуулж, дээрэлхэлтийн шалтгаан, хэлбэрүүд, урьдчилан сэргийлэх талаар харилцан ярилцав.

### Хоёр

“Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй” аяны удирдамжийг багш, ажилчид, сурагчдад танилцуулав. Аяны видео, контент, постер мэдээллийг “Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургууль”-ийн пейж хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлах ажлыг хийсэн..

### Гурав

Үе тэнгийн дээрэлхэлтийн талаар мэдээлэл хүлээн авах санал хүсэлтийн хайрцгийг 1-р давхрын үүдэнд байршуулсан бөгөөд ямар нэгэн санал хүсэлт ирээгүй.



## Дөрөв

Сургуулийн үүдний зааланд байрлах зурагтаар дуу, бичлэг, контентыг тавьж түгээн дэлгэрүүлсэн.

- 1-12-р ангийн эцэг эхийн нэгдсэн хурлаар "Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй", "1 дүгээрт хүүхэд" сэдэвт зөвлөмж боловсруулан 209 эцэг эх, асран хамгаалагчдад түгээн танилцуулсан.

- Сургуулийн өгсөх шатанд эерэг үг түгээх хэвлүүлэн наасан.

## Тав

10-12-р ангийн 64 сурагчид "Хорт зуршлаас сэргийлье", "Зам тээврийн осол", "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" сэдэвт сургалтуудыг сумын хэсгийн төлөөлөгчтэй хамтран зохион байгуулав.

6-12-р ангийн 152 сурагчдад "Жендер", "Жендерийн хэвшмэл ойлголт" –ын талаарх сургалтыг хийв.

"Харилцан хүндэтгэе" аяны уриа, мэдээллийг сургуулийн цахим хуудсаар дамжуулан 875 хүнд түгээн дэлгэрүүлсэн.

## Зургаа

ГБХЗХГ-ын мэргэжилэнтэй хамтран "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга", "Бие биеэ хүндэтгэх" сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

"Чи ганцаараа биш" аяны хүрээнд гаргасан видео, контент, шторкийг сургуулийн пейж хуудсаар дамжуулан 344 эцэг эх, асран хамгаалагч, олон нийт, 107 суралцагч, 18 багш, 15 ажилтанд хүргэн ажиллалаа.











## Долоо

Сургуулийн бага ангиудын хичээллэдэг коридорт “Номын өргөө”-г бага ангийн багш Л. Мөнхгэрэл 2600000 төгрөгөөр тохижуулав. Энэ нь тэдний хүсэл сонирхолд нийцсэн сайхан ажил боллоо.



## Найм

Хилийн заставын дугаар ангийн алба хаагчид дотуур байрны охидын өрөөг тохижуулж өглөө.



## Ес

Дотуур байрын уншлагын танхимыг эцэг эхийн санаачлага, дэмжлэгээр тохижуулав. Ахмад багш Д. Март сурагчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх олон талт хүмүүжлийн ажил зохиож, дугуйлан хичээллүүлж байна.





## 7. Байгууллагын орчны эрсдлийг бууруулах, дотоод хяналтыг тогтмолжуулан, тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцох

### Нэг

Сургууль, дотуур байрны дотоод гадаад орчны эрсдлийн үнэлгээг зохион байгуулав. Энэхүү үнэлгээгээр сургуулийн хичээлийн байр дунд эрсдэлтэй, дотуур байр их эрсдэлтэй үнэлэгдэв.

### Хоёр

1-12-р ангийн сурагчдын “Эрсдлийн үнэлгээ”-г анги удирдсан багш нартай хамтран хийж, сургуулийн нэгдсэн судалгааг гаргасан.

### Гурав

Сургуулийн хичээлийн байранд эрсдлээс сэргийлэх зорилгоор хяналтын 25 камер байрлуулж 7 хоног бүр хяналтын бичлэгийг хянаж хэвшсэн.

## 8 . Шинэлэг, онцлог, бусдад туршлага болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээ

Багш, ажилтан суралцагчидтай ганцаарчилсан уулзалт хийхэд маш сайн ойлголцож, ажиллахад таатай орчин бүрддэг.

ОХУ-ын Борзийн районы Соловьёвск тосгоны сургуультай хамтран ажилласнаар багш нарын арга зүй, суралцагчдын англи, орос хэлээр илтгэл тавих, шүлэг унших чадвар ахьсан.

“Хүн багаасаа” бүжгийн хамрагдаж сурагчдын хувцсыг ажилчдын болсон.

болох төслийн дугуйланд байгаа бүжгийн оёдог багтай

Ахмад багш нартай хамтран ажиллаж, багш нарын ажлын тайланг хэлэлцүүлж, тэднээр үнэлүүлэн зөвлөгөө өгөх ажил нь үр дүнтэй байлаа.

Сургуулийн “Сайхан бичигтэн” анги, хамт олон, суралцагч шалгаруулах уралдааныг зохион байгуулсан. Шагналын санг сумын Засаг Дарга ивээн тэтгэв.



# Хөдөлмөр зуслан ажиллуулж эхэллээ.

**Narangerel Viktor**  
21 мин · 🧑

🌱 Хүмүүс их сонирхож асууж утасдаж бүртгүүлж байна.Тиймээс нэмэлт мэдээлэл оруулья.Цаашид ч үйл ажиллагаагаа тайлагнаж пост оруулж байна.Хүүхдийн хөгжил хамгааллын ажлын хүрээнд сумын Засаг дарга,ЕБС-ийн дэмжлэгээр "Улз"хөдөлмөр зуслан хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн бөгөөд зуслангийн маань үйл ажиллагаа 2024.06.21-нээс эхлэх бөгөөд бүртгэл хийгдсээр байна.

Суралцах зүйл;

- 🇮🇹 1.Монгол шагай наадгай,үнээ сааж тугал ивэлгэх, цагаан идээ боловсруулах,хүнсэндээ хэрхэн зөв хэрэглэх
- 🥒🍅 2.Хүнсний ногоо тариалах ,арчлах,даршлах
- 🧶🧶 3.Оёдол эсгүүр хийх,товч шилбэ зангидах,хадах,олбог ширэх
- 🧑🧑 4.Математикийн хоцрогдол арилгах хичээл
- 🏐 5.Элсний волейболийн хичээл
- 🏆 6.Зургийн хичээл тус тус хичээллэнэ таны хүүхдийн зуны амралтыг дурсамжтай ,аз жаргалаар дүүрэн🥰 үр дүнтэй өнгөрүүлэхэд хамтран ажиллаж тусланаа.📺📺Манай сум руу галт тэрэг зорчидог учраас 2 дахийн өглөө ирээд 5 дахьд буцах 3 хоног,5дахийн өглөө ирээд 2 дахь өдөр буцах 4 хоног мөн 7 хоногийн амралтанд амрах давуу талууд байгаа шүү. Та бүхэн хүүхдээ амжиж бүртгүүлээрэй.Дэлгэрэнгүй мэдээлэлийг энэ дугаараас аваарай:88386220

Жич:07.01- нээс хятад хэлний анхан шатны хичээл заагдана. Амраад буцахдаа хүүхдүүд маань өөрсдийн хийсэн дарсан ногоо,цагаан идээний багц бэлгэнд авна гоё уу 🌸🌟

👍 Лхүндэв Мөнхцэцэг, Gnchmg Chimeg ба өөр 1 хүн

👍 Таалагдлаа    💬 Сэтгэгдэл    🗨 Илгээх

Сумын ОНХС- аас 20 сая төгрөгийн санхүүжилтээр 4 гэр болон доторх ор, ширээ, сандал, угаалтуурыг нийлүүсэн.



# Хөдөлмөр зуслан ажиллуулж эхэллээ.



Сумын ОНХС- аас 20 сая төгрөгийн санхүүжилтээр 4 гэр болон доторх ор, ширээ, сандал, угаалтуурыг нийлүүсэн.



# Хөдөлмөр зуслан ажиллуулж эхэллээ.



Сумын ОНХС- аас 20 сая төгрөгийн санхүүжилтээр 4 гэр болон доторх ор, ширээ, сандал, угаалтуурыг нийлүүсэн.



# Хөдөлмөр зуслан ажиллуулж эхэллээ.





# Анхааран сонссонд баярлалаа

